

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИЦУУЛАЛТ, НӨХЦӨЛ ШААРДЛАГ-Т НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

2016.07.22

Тус хороо нь 2016 онд харилцаа холбооны салбарын зохицуулалтын журам, нөхцөл шаардлагуудыг хянан үзэж, шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг оруулж, тухай бүр өөрийн цахим хуудсаар мэдээлж байсан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 15-р тогтоолоор батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-т Хорооны 2016 оны 12 тоот тогтоолоор болон 29 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар тус тус оруулсан засвар, нэмэлт өөрчлөлтүүдийг нэгтгэн танилцуулж байна.

1. Хорооны 2016 оны 29 тоот тогтоолын 2 дугаар хавсралттай холбоотой мэдээлэл.

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт нөхцөл шаардлагын 7.51.1-д “Сувгийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөрөө төрөлжсөн чиглэлээр бэлтгэн нэвтрүүлэх бөгөөд нэг хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 80 %-иас доошгүй нь төрөлжсөн чиглэлээр бэлтгэсэн агуулга байна” гэж заасны дагуу 2011 оноос эхлэн сувгийн үйлчилгээ эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгохдоо хөтөлбөрийн хувьд зөвхөн төрөлжсөн чиглэлээр бэлтгэн дамжуулах зорилго бүхий өргөдөл гаргагч этгээдэд ирүүлсэн хөтөлбөр төлөвлөлтийг үндэслэн төрөлжсөн чиглэл бүхий кабелийн сувгийн тусгай зөвшөөрөл олгож, нөхцөл шаардлага-г заасны дагуу хяналт, мониторинг хийж хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой ажлууд хийгдэж ирсэн.

ХХЗХ-ны зүгээс сувгийн хөтөлбөрийн төрөлжсөн чиглэлийн хувь хэмжээ шаардлага хангасан эсэхэд хяналт, мониторинг хийхдээ тухайн төрөлжсөн чиглэлд оруулж тооцох нэвтрүүлгүүдийг сэтгүүлзүйн үндсэн төрөл жанрыг баримтлан ангилдаг бөгөөд “ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН АНГИЛАЛ, ТӨРӨЛ ЖАНРЫГ ТОДОРХОЙЛОХОД БАРИМТЛАХ ЗАРЧИМ” нэртэй зөвлөмж боловсруулан гаргаж, үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлж, мониторингийн аргачлал, үзүүлэлтэд ашиглаж ирсэн.

Аливаа нэвтрүүлэг нь төрөл, хүргэх хэлбэр, агуулга зэргээс шалтгаалан хэд хэдэн ангилалд тооцогдох боломжтой маргаантай нөхцөлд байдал үүсдэг хэдий ч ХХЗХ-ны зүгээс сувгийн хөтөлбөрийн төрөлжсөн чиглэлд мониторинг хийхдээ тухайн нэвтрүүлгийг сэтгүүлзүйн үндсэн төрөл жанрыг баримтлан ангилахаас гадна нэвтрүүлгийн үзэгчдэд хүргэх хэлбэр, агуулга, хөтөлбөрийг зөв үнэлснээр сувгийн төрөлжсөн чиглэл, өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгуудын бэлтгэн хүргэж байгаа нэвтрүүлгийн талаар бодит мэдээлэл гарах, судалгааны чанартай мэдээлэл болох үндэслэл бүрдүүлэх асуудлыг давхар авч үздэг.

Сувгийн төрөлжсөн чиглэлд 2011-2015 онуудад хийсэн хяналт, мониторингийн дүнг авч үзээд 2015 оны 12-р сараас эхлэн бүх сувгуудтай төрөлжсөн чиглэл тус бүрээр уулзалт хийж дээрх зөвлөмжийн дагуу мониторингийн аргачлал, төрөлжсөн чиглэлд оруулж тооцож байгаа нэвтрүүлгүүдийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийж, хөтөлбөрт нэг бүрчлэн тулгалт хийж, зөвлөмж, мониторингийн аргачлалд зарим нэмэлт өөрчлөлт оруулж ажилласнаар нөхцөл шаардлага хэрэгжүүлэх, хяналт, мониторинг хийх, хэрэгжилтийг хангуулах талууд нэгдсэн ойлголтод хүрч байна.

Сувгийн төрөлжсөн чиглэлд хийсэн 2011-2015 оны мониторингийн нэгдсэн дүн, сувгуудын хөтөлбөрийн төрөлжилтийн байдал зэргийг 2016 оны 5-р сарын 25-ны өдрийн Хорооны хуралдаанд танилцуулж, сувгийн төрөлжсөн чиглэлийн талаар дараах шийдвэрийг гаргаж 29 тоот тогтоолын 2-р хавсралтаар батлан гаргалаа. Үүнд:

Нэг. Сувгийн төрөлжсөн чиглэл

№	Төрөлжсөн чиглэл	Дэд ангилал
1	Мэдээ, мэдээлэл	Мэдээ, мэдээллийн суваг
2	Танин мэдэхүй	Шинжлэх ухаан, танин мэдэхүйн суваг
		Байгаль, экологийн суваг
		Эрүүл мэндийн суваг
3	Хүүхэд	Хүүхдийн суваг

4	Нийгэм эдийн засаг	Нийгэм, эдийн засаг
5	Соёл урлаг, хөгжим	Соёл урлагийн суваг
		Хөгжмийн суваг
6	Цэнгээнт	Цэнгээнт суваг
		Хувцас загварын суваг
7	Кино	Кино суваг
8	Спорт	Спорт суваг
9	Теле- худалдаа	Теле-худалдааны суваг

Хоёр. Танин мэдэхүй, Соёл урлаг хөгжим, Цэнгээнт сувгийн хувьд төрөлжсөн чиглэлийн ерөнхий ангиллаас гадна дэд чиглэлээр дагнан төрөлжиж болно.

Гурав. Сувгийн төрөлжсөн чиглэлд хамааруулж тооцох нэвтрүүлгийн төрөл ангиллын талаар дэлгэрэнгүй зөвлөмж гаргаж мөрдүүлнэ.

1.1. “Нийгэм-эдийн засаг” төрөлжсөн чиглэл болон энэ чиглэлээр төрөлжсөн сувгуудтай холбоотой шийдвэрийн талаар

Тус хорооноос 2011-2015 онд хийгдсэн хяналт, мониторингийн дүнд үндэслэн тус хорооны 2016 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хорооны хуралдааны тэмдэглэлээр дараах чиглэлийг гаргалаа. Үүнд:

- Нийгэм эдийн засаг төрөлжсөн чиглэлийн сувгуудын хувьд 1 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 100 %-иас доошгүй нь төрөлжсөн чиглэлээр бэлтгэн дамжуулсан нэвтрүүлэг байна. Тухайлбал 100 % нийгэм, эдийн засаг чиглэлээр төрөлжсөн байх
- Цаашид Нийгэм эдийн засгийн чиглэлээр сувгийн зөвшөөрөл олгохгүй, цаашид сувгийн бусад чиглэлийг нийгэм, эдийн засаг болгон өөрчлөлт оруулахгүй байхаар тус тус шийдвэрлэлээ.

2. Хорооны 2016 оны 12 тоот тогтоолоор баталсан нэмэлт, өөрчлөлтүүдтэй холбоотой мэдээлэл.

2.1. Нэмэлт, өөрчлөлтийн талаарх нэгдсэн мэдээ

№	Нэр	Батлагдсан огноо	Тогтоолын дугаар	Төрөл	Тайлбар	Агуулгын өөрчлөлт орсон эсэх	Нэр өөрчилсөн эсэх
---	-----	------------------	------------------	-------	---------	------------------------------	--------------------

2.2. Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлагаас хассан заалтууд

1	Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага	2015-03-23	15	Нөхцөл шаардлага	Шинээр баталсан	Нийтлэг шаардлага ерөнхий өөрчилсөн. 4.3, 4.4, 6.2, 10.6, 14.2, 15.7 хассан. 6.1, 6.9, 7.11, 7.12, 11.38, 12.10.1, 15.6 найруулсан. 12.22, 12.23, 14.3.4 нэмсэн. 6.13.8, 7.36, 7.50, 8.1, 8.2.2, 8.3, 9.1, 10.1, 10.5.2, 10.6, 11.27, 11.28 нэмэлт, өөрчлөлт оруулсан. 6.13 тогтоолын дугаар, огноог хассан.	Өөрчлөлт байхгүй
---	--	------------	----	------------------	-----------------	--	------------------

№	Хасагдсан заалтын дугаар	Хасагдсан заалтын агуулга
1	4.3	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг дараах төрлөөр олгоно: 4.3.1. Телевиз, радиогийн газрын дахин дамжуулах сүлжээний үйлчилгээ эрхлэх(цаашид тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ гэх) 4.3.2. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэх 4.3.3. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх
2	4.4	4.4. Тусгай зөвшөөрлийг зах зээлийн хамрах хүрээгээр нь дараах төрөлд хуваана. 4.4.1. Улаанбаатар хот; 4.4.2. Аймаг, сум; 4.4.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт
3	6.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны хуулинд заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд үйл ажиллагаа эхлүүлсэн байна.
4	10.6	Сувгийг дамжуулах трактын тоног төхөөрөмжүүдэд дуу, дүрсийн хэмжилт хийхдээ MNS 5592-2:2006 стандартад заасан шалгалтын /тест/ дохионуудыг ашиглах бөгөөд техник стандартын шаардлага хангасан байна.
5	14.2	Энэхүү нөхцөл шаардлагын 14.1-д заасан хяналтыг шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.
6	15.7	Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлөөр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, холбогдох хууль тогтоомжийг зөрчиж тусгай зөвшөөрлөө цуцлуулсан бол тусгай зөвшөөрөл цуцалснаас 3 жил хүртэлх хугацаанд тусгай зөвшөөрөл дахин олгохоос татгалзана.
7	6.13.9 6.13.10	6.13.9. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь студийн гаралтандаа дуу, дүрсийн түвшин тохируулах, хянах, хэмжилтийн тоног төхөөрөмжийг суурилуулсан байх ба хэмжилт хяналтыг тогтмол хийж гүйцэтгэнэ. 6.13.10.ОСДҮЭ нь телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн дуу, дүрсийн сигналыг хүлээн авах оролтондоо дуу, дүрсийн түвшинг тохируулах, хянах тоног төхөөрөмжийг суурилуулсан байна.

2.3. Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага-т найруулж, засвар оруулсан заалтууд

№	Найруулж зассан заалтууд	Хорооны 2015 оны 15-р тогтоолоор батлагдсан заалт	Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан
---	--------------------------	---	--

1	6.1.	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөлд заасан хамрах хүрээнд үйл ажиллагаа явуулна.	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлд заасан хамрах хүрээнд үйл ажиллагаа явуулна.
2	6.9	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос гаргасан шилжилтийн үед өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах зохицуулалтын баримт бичгийг мөрдөж, тоон технологид шилжинэ.	6.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос баталсан “Телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог системийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах зохицуулалт”-ыг баримталж тоон технологид шилжинэ.
3	7.11. 7.12	Соёлын тухай хуулийн 19-р зүйлд заасны дагуу Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн дамжуулж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 50 %-иас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.	7.11. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дамжуулахдаа Соёлын тухай хуулийн 19-р зүйлийг ¹ мөрдөнө. 7.12. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дамжуулахдаа Соёлын тухай хуулийн 19-р зүйлийг ² мөрдөнө
4	11.38	Сүлжээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор 24 цагийн удирдлага, хяналтын нэгдэн систем (operation and maintenance system)-тэй байх ба техник төхөөрөмжийн технологийн горимыг мөрдөж ажиллана. Бусад телевиз, кабелийн сувгуудаас хүлээж авч байгаа дуу, дүрсийн дохионы түвшин, сүлжээний гэмтэл саатал гарсан даруйд гэмтлийг бүртгэн дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.	11.28. Телевиз, сувгуудын дуу дүрсийн чанарыг MNS 5592-2:2016 стандартад заасан хэмжээнээс бууруулахгүйгээр дамжуулах үүрэгтэй. 11.28.1. Хэрэглэгчийн төхөөрөмж (Settop box) дээрх телевиз, сувгуудын дохионы дууны түвшин стандарт шаардлага хангасан эсэх, телевиз, суваг бүрийн дууны дохио жигд байгаа эсэхэд хяналт тавина. 11.28.2. Телевиз, сувгуудаас эфир эхлэхдээ өгсөн шалгалтын /тест/ дохиог тухай бүр хэмжиж, тохиргоо хийлгэнэ.
6	12.10.1	12.10. Зохицуулах хорооноос телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо дараах шалгуур үзүүлэлтийг авч үзнэ. 12.10.1. чанартай үйлчилгээ хүргэх техникийн чадвар, тухайн	12.10.1. Чанарын шаардлага хангасан үйлчилгээ хүргэх техникийн чадавхи

^{1, 2} Олон нийтийн телевизээс бусад Монгол Улсад бүртгэлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

		үйлчилгээний харгалзах	онцлогийг
10	15.6.	Хэрэв энэхүү нөхцөл шаардлагыг зөрчсөний улмаас тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл аваад үйл ажиллагаагаа эхлээгүй, үйл ажиллагаа эхлээд 1 жил болоогүй тохиолдолд дахин тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.	Хэрэв энэхүү нөхцөл шаардлагыг зөрчсөний улмаас тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл аваад 1 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа эхлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцална. 12.10.2.

2.4. Шинээр нэмэгдсэн заалтууд

№	Нэмэгдсэн заалтын дугаар	Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар нэмсэн заалтууд	
1	12.22 12.23	12.22 Телевиз, сувгуудаас авч байгаа дуу, дүрсийн дохио нь MNS 5592-2:2016 стандартад заасан үзүүлэлтийг хангасан байх шаардлагыг телевиз, сувгуудад тавьж ажиллана.	12.23 Телевиз, сувгуудын дуу дүрсийн чанарыг Монгол улсын үндэсний стандарт болон олон улсын стандарт зөвлөмжүүдэд заасан хэмжээнээс бууруулахгүйгээр дамжуулах үүрэгтэй. 12.23.1 Хэрэглэгчийн төхөөрөмж (Settop box) дээрх телевиз, сувгуудын дохионы дууны түвшин стандарт шаардлага хангасан эсэх, телевиз, суваг бүрийн дууны дохио жигд байгаа эсэхэд хяналт тавина. 12.23.2 Телевиз, сувгуудаас эфир эхлэхдээ өгсөн шалгалтын /тест/ дохиог тухай бүр хэмжиж, тохиргоо хийлгэнэ.

2.5. Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалтууд

№	Өөрчлөлт орсон заалтууд	Хорооны 2015 оны 15-р тогтоолоор батлагдсан заалт	Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан
1	6.13.8	6.13.8. Нэвтрүүлгийн дуу, дүрсийн гаралтын чанарын үзүүлэлтийг хангаж ажиллах бөгөөд студийн гаралтын дүрс болон дууны түвшин, кабель шугамын чанарын үзүүлэлтийг хянах техникийн боломжийг бүрдүүлэн, дуу дүрсийн хэмжилтийн тоног төхөөрөмжтэй байж, хэмжилт хяналтыг тогтмол хийж гүйцэтгэнэ.	6.12.8. Нэвтрүүлгийн дуу, дүрсийн гаралтын чанарын үзүүлэлтийг хангаж ажиллах бөгөөд студийн гаралтын дүрс болон дууны түвшин, кабель шугамын чанарын үзүүлэлтийг хянах, дууны чанга сулын түвшинг /Loudness/ телевиз, сувгууд студийн ерөнхий гаралтандаа, ОСДҮЭ оролтондоо тохируулах техникийн боломжийг бүрдүүлэн, дуу дүрсийн хэмжилтийн тоног төхөөрөмжтэй байж, хэмжилт хяналтыг тогтмол хийж гүйцэтгэнэ. Тухайн сарын хэмжилтийн дүнг дараа сарын 15-ны дотор Зохицуулах хороонд ирүүлнэ.
2	7.36	Зар сурталчилгааны цагаас бусад цагт нэвтрүүлж буй нэвтрүүлгийн үеэр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний баннер хэлбэрийн зар сурталчилгаа, логог дэлгэц дээр давхардуулан гаргахгүй байна.	Зар сурталчилгааны цагаас бусад цагт нэвтрүүлж буй нэвтрүүлгийн үеэр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний баннер хэлбэрийн зар сурталчилгаа, лого-г дэлгэц дээр гаргахгүй байна.

3	7.50.	Бусад студиес нэвтрүүлгийн бичлэг хүлээн авахдаа дуу, дүрсийн хувьд MNS 5592-2:2006; MNS 5591-2-:2006 стандартын шаардлага хангасан эсэх, агуулгын талаар холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.	Бусад студиес нэвтрүүлгийн бичлэг хүлээн авахдаа дуу, дүрсийн хувьд MNS 5592-2:2016; MNS 5591-2-:2006 стандартын шаардлага хангасан эсэх, агуулгын талаар холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.
4	8.1.	3. Зайлшгүй байх мэргэжилтэй ажилтны тоо (найруулагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч, зураглаач, эвлүүлэгч)	3. Зайлшгүй байх мэргэжилтэй ажилтны тоо (найруулагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч, зураглаач, эвлүүлэгч, дууны найруулагч)
5	8.2.2	MNS 5592-2:2006: Телевизийн студи-Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага	MNS 5592-2:2016: Телевизийн студи-Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага
6	8.3.	Телевизийн сувгийг дамжуулах трактын тоног төхөөрөмжүүдэд дуу, дүрсийн хэмжилт хийхдээ MNS 5592-2:2006 стандартад заасан шалгалтын /тест/ дохионуудыг ашиглах бөгөөд техник стандартын шаардлага хангасан байна. 1.1. Студийн тоног төхөөрөмж холболтын SDI, HD-SDI интерфейсгүй байна.	Эфир эхлэхээс 30 минутын өмнө MNS 5592-2:2016 стандартад заасан үзүүлэлт бүхий дуу, дүрсийн дохиог дамжуулж, ОСДҮЭ-ийн оролтонд хэмжилт хийлгэн, хэмжилтийн дүнд үндэслэн тохиргоо хийх замаар нэвтрүүлэг дамжуулах трактын тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг шалгана.
7	9.1.	3. Зайлшгүй байх мэргэжилтэй ажилтны тоо (найруулагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч, зураглаач, эвлүүлэгч)	3. Зайлшгүй байх мэргэжилтэй ажилтны тоо (найруулагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч, зураглаач, эвлүүлэгч, дууны найруулагч)
8	10.1	3. Зайлшгүй байх мэргэжилтэй ажилтны тоо (найруулагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч, зураглаач, эвлүүлэгч)	3.Зайлшгүй байх мэргэжилтэй ажилтны тоо (найруулагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч, зураглаач, эвлүүлэгч, дууны найруулагч)
9	10.5.2	MNS 5592-2:2006: Телевизийн студи-Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага	MNS 5592-2:2016: Телевизийн студи-Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага
10	10.6	Сувгийг дамжуулах трактын тоног төхөөрөмжүүдэд дуу, дүрсийн хэмжилт хийхдээ MNS 5592-2:2006 стандартад заасан шалгалтын /тест/ дохионуудыг ашиглах бөгөөд техник стандартын шаардлага хангасан байна.	Эфир эхлэхээс 30 минутын өмнө MNS 5592-2:2016 стандартад заасан үзүүлэлт бүхий дуу, дүрсийн дохиог дамжуулж, ОСДҮЭ-ийн оролтонд хэмжилт хийлгэн, хэмжилтийн дүнд үндэслэн тохиргоо хийх замаар нэвтрүүлэг дамжуулах трактын тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг шалгана.
11	11.27	Телевиз, сувгуудаас авч байгаа дуу, дүрсийн дохио нь MNS 5592-2:2006 стандартад заасан үзүүлэлтийг хангасан байх шаардлагыг телевиз, сувгуудад тавьж ажиллана.	Телевиз, сувгуудаас авч байгаа дуу, дүрсийн дохио нь MNS 5592-2:2016 стандартад заасан үзүүлэлтийг хангасан байх шаардлагыг телевиз, сувгуудад тавьж ажиллана.
12	11.28	Телевиз, сувгуудын дуу дүрсийн чанарыг MNS 5592-2:2006 стандартад заасан хэмжээнээс бууруулахгүйгээр дамжуулах үүрэгтэй ба сувгуудын дуу, дүрсийн болон кабель шугамын чанарын үзүүлэлтийг хянах техникийн боломжийг бүрдүүлэн дуу, дүрсийн хэмжилтийн төхөөрөмжтэй байж хэмжилт хяналт тогтмол хийнэ.	Телевиз, сувгуудын дуу дүрсийн чанарыг MNS 5592-2:2016 стандартад заасан хэмжээнээс бууруулахгүйгээр дамжуулах үүрэгтэй. 1.1.1. Хэрэглэгчийн төхөөрөмж (Settop box) дээрх телевиз, сувгуудын дохионы дууны түвшин стандарт шаардлага хангасан эсэх, телевиз, суваг бүрийн дууны

			<p>дохио жигд байгаа эсэхэд хяналт тавина.</p> <p>1.1.2. Телевиз, сувгуудаас эфир эхлэхдээ өгсөн шалгалтын /тест/ дохиог тухай бүр хэмжиж, тохиргоо хийлгэнэ.</p>
--	--	--	---